



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/82

Хархорин сум

Хагас жилийн малын түүвэр судалгааг
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.1, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.в, Малын индексжүүлсэн даатгаын тухай хуулийн 6 дугаар хэсэг, аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 16-ний өдрийн А/401 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хагас жилийн малын түүвэр судалгааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хагас жилийн малын түүвэр судалгааг чанартай явуулах бэлтгэл, ажлыг багийн түвшинд хангуулах, түүвэр судалгаанд ажиллахаар томилогдсон тоологч нарын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, судалгааны дүнг мэдээллийн санд шивж оруулах ажлыг удирдан зохион байгуулах, хагас жилийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний хооронд зохион байгуулж, хяналтын тооллого хийж, дүн мэдээллийг хугацаанд нь хүлээлгэн өгөхийг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Малын түүвэр судалгааны бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг сум, багийн түвшинд хангаж, судалгааг тогтоосон хугацаанд заавар журмын дагуу чанартай явуулж, дүнг мэдээллэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

■ 401100161

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 22 ны өдрийн А/Б/2
дугаар захирамжийн хавсралт

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Э.Үүрцайх (Мал аж ахуйн асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Ц.Баатарсүрэн (Байгаль орчны асуудал
хариуцсан мэргэжилтэн)

Э.Очир-Эрдэнэ (Архитектор)

Н.Төгөлдөр (Байгаль хамгаалагч)

О.Гангаацэрэн (Нягтлан бодогч)

Т.Алтангэрэл (1-р багийн Засаг дарга)

Б.Пүрэвсүрэн (1-р багийн зохион байгуулагч)

Р.Сүхбат (2-р багийн Засаг дарга)

Б.Сарангэрэл (1-р багийн зохион байгуулагч)

Д.Батчулуун (3-р багийн Засаг дарга)

Д.Хишигсүрэн (3-р багийн зохион байгуулагч)

Г.Отгонбаяр (4-р багийн Засаг дарга)

Б.Ганхуяг (5-р багийн Засаг дарга)

Л.Төгөлдөр (6-р багийн Засаг дарга)

О.Батсүх (7-р багийн Засаг дарга)

П.Нэндарам (8-р багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалан хариуцсан
мэргэжилтэн)

--oOo--